

**“МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД” ТӨСЛИЙН ТӨГСГӨЛИЙН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ТОВЧОО**
(2016 оны жилийн эцсийн байдлаар)

2017 оны 03 дугаар сарын 29

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл				
1.	Төсөл, хөтөлбөрийн нэр	Малын эрүүл мэнд төсөл Төслийн дугаар: 7F-06231.02				
	Төсөл, хөтөлбөрийн шийдвэрийн дугаар:	Швейцарь Улс, Монгол Улсын Засгийн газар хоорондын Хүмүүнлэгийн тусламж, техникийн хамтын ажиллагааны тухай ерөнхий хэлэлцээр, 2006.05.16, Швейцарын хөгжлийн агентлаг болон Сангийн яамны хооронд байгуулсан Хөгжлийн хамтын ажиллагаа, хүмүүнлэгийн тусламжийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх журмын тухай хэлэлцээр, 2007.06.01.				
	Төслийн зорилго:	Монгол улсад мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах тогтолцоог сайжруулж, илүү үр дүнтэй болгоход дэмжлэг үзүүлнэ.				
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	Төслийн нийт санхүүжилт 5.9 сая швейцарь франк				
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: ШХА-ийн төслийн зохицуулах нэгж				
		Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: ХХААХҮЯ, Сангийн яам, МЭҮГ, МЭБС				
		Хугацаа: 2012-2016 он				
4.	Төслийн зорилтууд	<ol style="list-style-type: none"> 1. Мал эмнэлгийн албаны ажил үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлэхээр бодлого, хууль тогтоомжийг шинэчлэх 2. Бруцеллёз болон шүлхий өвчинтэй үр дүнтэй тэмцэх, хэмнэлттэй хяналтын хөтөлбөр бий болгох 3. Малын эмч бэлтгэх албан ёсны боловсролын агуулга, арга зүйг боловсронгуй болгох 				
5.	Зардал	ТӨСӨВ, швейцарь франкаар	Нийт	2012-2016 онд зарцуулсан		2016 онд зарцуул-н
		Бүрэлдэхүүн хэсэг-I:	730'000	617'580	84.6%	324'500
		Бүрэлдэхүүн хэсэг-II:	3'100'000	2'926'400	94.4%	365'160
		Бүрэлдэхүүн хэсэг-III:	920'000	910'800	99.0%	163'500
		Бүрэлдэхүүн хэсэг-IV:	1'190'000	975'800	82.0%	190'800
	ДҮН	5'940'000	5'430'580	91.4%	1'043'960	
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилт:		Биелэлтийн үнэлгээ			
	Төслийн 1 дүгээр зорилтын хүрээнд хүрэх үр дүн: Мал эмнэлгийн албаны ажил үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлэхээр бодлого, хууль эрх зүйн орчин шинэчлэгдсэн байна.		(Үнэлгээний тайлангийн 4-5 дугаар хуудаснаас харна уу.)			
	Төслийн 2 дүгээр зорилтын хүрээнд хүрэх үр дүн: Монгол улс Бруцеллёз болон шүлхий өвчинтэй үр дүнтэй тэмцэх, хэмнэлттэй хяналтын хөтөлбөр бий болгосон байна.		(Үнэлгээний тайлангийн 5-9 дүгээр хуудаснаас харна уу.)			
	Төслийн 3 дүгээр зорилтын хүрээнд хүрэх үр дүн: Малын эмч бэлтгэх албан ёсны боловсролын агуулга, арга зүйг боловсронгуй болгож сургалтын орчныг сайжруулсан байна.		(Үнэлгээний тайлангийн 9-10 дугаар хуудаснаас харна уу.)			
7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)		Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 86.0 %, үр дүнгийн үнэлгээ 90.0 хувиар дүгнэгдэв. (Үнэлгээний тайлангийн 13 дугаар хуудаснаас харна уу.)			
8	Төслийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ		Төслийг хэрэгжүүлэгч талууд боллоцоо, нөөцөө дайчлан хамтын ажиллагааг зохих түвшинд хэрэгжүүлж ажилласан.			
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Төсөл хэрэгжиж эхэлснээс хойших үнэлгээгээр)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
		90.0%	3	75.0%	96.7%	93.3%
	Төслийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)		Нэгдсэн үнэлгээ %			

**“МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД” ТӨСЛИЙН ТӨГСГӨЛИЙН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**
(2016 оны жилийн эцсийн байдлаар)

2017 оны 03 дугаар сарын 29

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Үнэлгээний зорилго нь арга хэмжээний гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй нь харьцуулан тогтоож, тэдгээрийн хоорондын зөрүүг илрүүлэн дүн шинжилгээ хийж шалтгааныг тодруулах, түүнд үндэслэн зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын дагуу 2016 оны жилийн эцсийн тайланг судлах, тухайн ажлыг хариуцсан албан тушаалтнуудтай уулзаж ярилцах, холбогдох газруудаас тодруулга авах замаар цуглуулсан мэдээ, мэдээлэлд үндэслэн гүйцэтгэв.

ГУРАВ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Анх уг төслийг хэрэгжүүлэх тухай гэрээ, хэлэлцээр Швейцарь Улс, Монгол Улсын Засгийн газар хоорондын Хүмүүнлэгийн тусламж, техникийн хамтын ажиллагааны тухай ерөнхий хэлэлцээрийг 2006 оны 05 дугаар сарын 16-нд байгуулсан бөгөөд энэхүү хэлэлцээр дээр үндэслэн Швейцарын хөгжлийн агентлаг /ШХА/ болон Сангийн яам “Хөгжлийн хамтын ажиллагаа, хүмүүнлэгийн тусламжийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх журмын тухай хэлэлцээр”-ийг 2007 оны 06 дугаар сарын 01-нд байгуулсан байна. Монгол улсын мал сүргийн эрүүл мэнд, түүнийг сахин хамгаалах хууль эрх зүйн орчин, мал эмнэлгийн байгууллагуудын бүтэц, тогтолцоо, мал эмнэлгийн албан боловсролын чанар, агуулга, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор дээр дурдсан хамтын ажиллагааны хүрээнд “Малын эрүүл мэнд” төслийн үйл ажиллагааг эхлүүлжээ.

Өвчинтэй тэмцэх стратегиудыг хэрэгжүүлэх, бүх түвшинд техникийн талын мэдлэгийг дээшлүүлэх замаар бруцеллёз, шүлхий өвчинтэй үр дүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх нь төслийн хамгийн гол хэсэг юм. Энэхүү зорилгод хүрэхийн тулд харилцан уялдаатай бодлого, хууль боловсруулах, түүнийг хэрэгжүүлж, мөрдүүлэх шаардлагатай. Энэхүү хувь нэмэр нь өвчнийг хянах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр ашгийг сайжруулах бөгөөд энэ нь мал эмнэлгийн салбарын ажилтнуудад ойлгомжтой өвчнийг хянах стратегүүдийг хэрэгжүүлэх тусгай чадавхи бий болгоход чиглэгдэнэ. Иймээс чадавхи бэхжүүлэх нь хэрэгцээнд-суурилсан, амьдралд ойрхон онолын болон дадлага сургалтаас бүрдэнэ. Төсөл нь энэхүү тогтолцоог тогтвортой байлгахын тулд их сургуулийн түвшинд малын эмчийн албан сургалтыг сайжруулна.

Төслийн зорилго: Малын эрүүл мэндийн тогтолцоог сайжруулах, түүнийг илүү үр дүнтэй болгоход хувь нэмэр оруулах.

Төслийн үргэлжлэх хугацаа: 2012-2016 он

Төслийн нийт санхүүжилт: 5.9 сая швейцарь франк

	2012 он	2013 он	2014 он	2015 он	Нийт Шф
Төслийн бүрэлдэхүүн хэсэг-1. Бодлого ба хууль эрх зүй	140000	250000	230000	110000	730000
Төслийн бүрэлдэхүүн хэсэг-2. Өвчинтэй үр дүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх	620000	980000	880000	620000	3100000
Төслийн бүрэлдэхүүн хэсэг-3. Мал эмнэлгийн албан сургалт	210000	160000	260000	290000	920000
Төслийн зохицуулах нэгж	230000	310000	310000	340000	1190000
Нийт	1200000	1700000	1680000	1360000	5940000

Хэрэгжүүлэгч байгууллагууд:

- Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: ШХА-ийн төслийн зохицуулах нэгж
- Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яам, Мал эмнэлэг үржлийн газар, ХААИС-ийн Мал эмнэлгийн сургууль

Төслийн бүрэлдэхүүн хэсэг-1. Бодлого ба хууль эрх зүй

Зорилт-1. Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллага (ДАЭМБ)-ын стандартын (Мал эмнэлгийн албаны гүйцэтгэлийг үнэлэх гарын авлага) дагуу шинэчлэх, техникийн болон зохион байгуулалтын чадавхийг дээшлүүлэх замаар мал эмнэлгийн төвийн болон орон нутгийн байгууллагуудыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах

Үр дүн-1. Монгол улс ДАЭМБ -ын стандартад заасны дагуу хүчирхэг, сайн зохион байгуулалттай, сайн бэлтгэгдсэн боловсон хүчинтэй мал эмнэлгийн албатай болно.

- 1.1. Малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлын шинэ хуулиуд боловсрогдон батлагдаж, зарим хэсэг нь хэрэгжиж эхэлнэ.
- 1.2. Хуулийг хэрэгжүүлэх шатанд мал эмнэлгийн албаны техникийн хүчин чадал сайжирч бэхжинэ.

Төслийн бүрэлдэхүүн хэсэг-2. Өвчинтэй үр дүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх

Зорилт-2. Өвчинтэй тэмцэх стратегиудыг хэрэгжүүлэх, бүх түвшинд техникийн талын мэдлэгийг дээшлүүлэх замаар бруцеллэз, шүлхий өвчинтэй үр дүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

Үр дүн-2. Монголын эрх бүхий хүмүүс малын бруцеллэз, шүлхий өвчнийг хянах чадавхитай болно.

- 2.1. Мал аж ахуй, хүний эрүүл мэндийн салбарын “Нэг эрүүл мэнд” үзэл баримтлал, ДАЭМБ стандартад үндэслэн өвчинтэй тэмцэх стратеги боловсруулж батлуулан хэрэгжүүлнэ. Үүнийг бруцеллэз, шүлхий өвчинтэй тэмцэхэд ашиглана.
- 2.2. Өвчинтэй тэмцэх стратегит үндэслэн ДАЭМБ-ын 2007 оны зөвлөмж, “Нэг эрүүл мэнд” үзэл баримтлалд нийцсэн бруцеллэз, шүлхий өвчний тандалт судалгаа, мониторингийн аргуудыг боловсруулж батлуулан хэрэгжүүлнэ.
- 2.3. Монголын мал эмнэлэг болон эрүүл мэндийн салбарууд нь бруцеллэз, шүлхий өвчнийг бүх шатандаа үр дүнтэй хянахад шаардлагатай мэдлэг болон чадвартай болсон байна. (Яам, Агентлаг, аймаг, сум, төрийн болон хувийн хүн эмнэлэг, мал эмнэлгүүд).

Төслийн бүрэлдэхүүн хэсэг-3. Мал эмнэлгийн албан сургалт

Зорилт-3. Төрийн болон хувийн мал эмнэлгийн үйлчилгээний шаардлагад үндэслэн сургалтын хөтөлбөрийг эргэж харах, багш нарыг сургах замаар их сургуулийн түвшинд малын эмчийн боловсрол олгох сургалтыг сайжруулахад хувь нэмэр оруулах

Үр дүн-3. ХААИС-ийн Мал эмнэлэг, биотехнологийн сургуулийн Малын эмчийн бакалаврын зэрэг олгох албан сургалтыг орчин үеийн хөтөлбөрт суурилсан, өрсөлдөхүйц чадвартай багш нар заана.

- 3.1. МЭБС-д гадны үнэлгээ цогц байдлаар хийгдэж үр дүнг бүх ашиг хүртэгч нарт мэдээлнэ.
- 3.2. МЭБС дээр боловсон хүчний хэрэгцээнд суурилсан хүйсийн тэгш байдлыг хангасан мастер төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.
- 3.3. Сургалтын материал боловсруулах, сургалтын лабораторийн үндсэн тоног төхөөрөмжийг худалдан авах, номын сангийн хэрэгцээнд-суурилсан мастер төлөвлөгөөг боловсрогдож хэрэгжинэ.

ДӨРӨВ. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**4.1. Төслийн үйл ажиллагааны санхүүгийн гүйцэтгэл (швейцарь франкаар)**

Зорилт	Нийт төсөв	2012-2016 онд зарцуулсан төсөв		2016 оны гүйцэтгэл
Бүрэлдэхүүн хэсэг-I: Мал эмнэлгийн салбарын бодлого, хууль эрх зүйн орчныг шинэчлэн сайжруулах	730'000	617'580	84.6%	324'500
Бүрэлдэхүүн хэсэг-II: Өвчнийг хянах хяналтын тогтолцоог шүлхий, бруцеллөз өвчний жишээн дээр сайжруулах	3'100'000	2'926'400	94.4%	365'160
Бүрэлдэхүүн хэсэг-III: Мал эмнэлгийн албан боловсролын тогтолцоог шинэчлэх сайжруулах	920'000	910'800	99.0%	163'500
Бүрэлдэхүүн хэсэг-IV: Төслийн удирдлага, зохион байгуулалт	1'190'000	975'800	82.0%	190'800
ДҮН	5'940'000	5'430'580	91.4%	1'043'960

4.2. Төслийн үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн

Төсөл хэрэгжүүлэхдээ аль нэг аймаг, сумыг тусгайлан сонгоогүй бөгөөд үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулсан байна. Малын өвчнийг хянах бодлогын гол асуудлыг хуульчлах, халдварт өвчинтэй тэмцэх стратеги боловсруулж, хэрэгжүүлэх, өвчний тархалтыг зогсоох, хяналтад авах үйл ажиллагааг үнэлэх, хянах механизмыг бий болгоход төсөл чухал хувь нэмэр оруулсан байна. Түүнчлэн чадавхи бэхжүүлэх үйл ажиллагааны элементүүдэд зорилтот хүрээний шийдвэр гаргагчид, Засгийн газрын байгууллагуудын албан хаагчид, мал эмнэлгийн бүх шатны байгууллагын мэргэжилтэн, ажилтан, техникийн ажилтан болон багшлах боловсон хүчин хамрагджээ.

Төслийн бүрэлдэхүүн хэсэг-1. Бодлого ба хууль эрх зүй**1.1. Малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлын шинэ хуулийн төслийг боловсруулан батлуулж, зарим хэсгийг хэрэгжүүлж эхлэх зорилтын хүрээнд:**

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн төсөл боловруулах ажлын хэсэг 2013 оны 02 дугаар сард Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын тушаалаар байгуулагдан ажиллалаа. Ажлын хэсгийн боловсруулсан хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд дэмжсэн тул 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хурал (УИХ)-д өргөн барьсан. УИХ-ын 2016 оны намрын чуулганы нэгдсэн хуралдаанаар тус хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжсэн бөгөөд 2017 оны хаврын чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалтад орсон болно.

“Мал, амьтны эрүүл мэндийн тухай” хуулийн төслийг боловсруулахад Малын эрүүл мэнд төслийн оруулсан хувь нэмэр:

- МЭМТ-ийн зүгээс ажлын хэсгийн өдөр тутмын үйл ажиллагааг дэмжих, гишүүдээс хуулийн төслийн талаар санал, хүсэлт авах, гарсан өөрчлөлтийг хуулийн төсөлд оруулах, хуулийн төслийн талаар сургалт, сурталчилгааг олон нийтэд хүргэх, шаардлагатай тохиолдолд ажлын хэсгийн уулзалтыг зохион байгуулахад санхүүжүүлэх үүрэгтэйгээр оролцсон.
- Швейцарийн хүнсний аюулгүй байдал, мал эмнэлгийн газраас мэргэжил, арга зүйн туслалцаа авч хуулийн төсөлд Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийг тусгаж багаа эсэхэд анхаарал хандуулан ажилласан.
- Танилцах аялал зохион байгуулж УИХ-ын гишүүд, Засгийн газрын гишүүдэд Швейцарийн холбооны улс, ХБНГУ-ын туршлагыг танилцуулсан.

1.2. Хуулийг хэрэгжүүлэх шатанд мал эмнэлгийн албаны техникийн хүчин чадлыг сайжруулан бэхжүүлэх зорилтын хүрээнд:

Малын эрүүл мэнд төсөл нь шийдвэр гаргагч, мэргэжилтнүүдийн дунд “Мал, амьтны эрүүл мэндийн тухай” хуулийн төслийн талаар мэдээлэл түгээх чиглэлээр дараах ажлууд хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Хуулийн төсөлд тусгагдсан голлох өөрчлөлтүүдийн талаар уулзалт, семинар болон телевизийн хөтөлбөрөөр дамжуулан мэдээлсэн.
- Олон улсын жишигт нийцүүлэхийн тулд “Мал, амьтны эрүүл мэндийн тухай” хуулийн төсөл боловсруулах болсон талаар нэр хүндтэй малын эмч нараас ярилцлага авав. Хуулийн тухай энэхүү цуврал ярилцлагыг Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз”-ээр нэвтрүүлж, холбогдох байгууллагуудын цахим хуудас болон олон нийтийн сүлжээгээр дамжуулсан.
- Монголын Мал эмнэлгийн холбооноос зохион байгуулдаг мал эмнэлгийн бүсийн бага хурлыг дэмжиж тэр үеэр хуулийн төслийн агуулга, уялдаа холбооны талаар зөвлөлдсөн.
- “Мал, амьтны эрүүл мэндийн тухай” хуулийн төсөлд малын эмч хүнсний аюулгүй байдал болон хүн амын эрүүл мэндийг хамгаалахад чухал үүрэгтэй оролцдог талаар мэдээлэл бэлтгэн хэвлүүлж 6 аймгийн шийдвэр гаргагчид, малын эмч, мал эмнэлгийн байцаагчдад хүргүүлэн танилцуулсан.
- ХХААХҮЯ-тай хамтран “Хувийн мал эмнэлгийн нэгжийн үйлчилгээ үзүүлэх эрх, зүйн орчин” сэдвийн хүрээнд жижиг амьтны болон адууны эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдийн төлөөлөл, байцаагчид, шийдвэр гаргагчид, хувийн мал эмнэлгийн нэгжийн төлөөлөл оролцсон семинар зохион байгуулсан байна. Төлөөлөгчид аймаг, сумын мал эмнэлгийн нэгжид тавигдах стандартыг жижиг амьтны эмнэлэгт тавигдах стандартаас ялгаатай байлгах талаар санал гаргалаа.
- Малын эмийн зохистой хэрэглээ төлөвшөөгүй, буруу хэрэглээнээс үүдэн нийгмийн эрүүл мэндэд хор, хохирол учирч байна. ХХААХҮЯ-ны эмийн зөвлөлтэй хамтран малын эмийг зүй зохистой хэрэглэх дадал эзэмшүүлэх сургалтыг Архангай, Булган, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Хөвсгөл аймагт зохион байгуулж үүнд 160 малын эмч, 116 малчид хамрагдсан.

Төслийн бүрэлдэхүүн хэсэг-2. Өвчинтэй үр дүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх

2.1. Мал эмнэлэг, хүний эрүүл мэндийн салбарын “Нэг эрүүл мэнд” үзэл баримтлал, ДАЭМБ-ын удирдамж, зөвлөмжид үндэслэн бруцеллёз, шүлхий өвчинтэй тэмцэх стратеги боловсруулж батлуулан хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

Мал эмнэлэг, эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналтын байгууллагууд, тэдгээрийн холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран бруцеллёз, шүлхий өвчинтэй тэмцэх стратегийг батлуулан хэрэгжилтийг зохион байгуулсан.

Шүлхийн халдвараас эрт сэрэмжлүүлж, хариу арга хэмжээг шуурхай, **оновчтой** зохион байгуулах зорилго бүхий Шүлхий өвчинтэй тэмцэх дунд хугацааны стратеги /2014-2018 он/ болон Бэлэн байдлын үндэсний төлөвлөгөөг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын 2014 оны 9 дүгээр сарын 25-ны А/112 тоот тушаалаар баталсан. Энэ нь баруун бүсийг “вакцин тарьдаггүй шүлхий өвчингүй бүс”-ийн статустай болгон олон улсад хүлээн зөвшөөрүүлэх, зүүн бүсэд гарч буй шүлхийн тархалтыг хянах зорилготой юм. ДАЭМБ-ын Хуурай газрын амьтны эрүүл мэндийн код (2015 он)-ын дагуу боловсруулсан Монгол улсын Шүлхийтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг ДАЭМБ-ын Ерөнхий чуулганаас хүлээн зөвшөөрч 2016 оны 5 дугаар сарын 24-ний өдөр батламжиллаа. Ийнхүү Монгол улс Шүлхийтэй тэмцэх үндэсний хөтөлбөрөө албан ёсоор батлуулсан ДАЭМБ-ын 9 дэх гишүүн, Ази-Номхон далайн бүсийн 3 дах орон болов. Энэ бол Монгол улсын шүлхийтэй тэмцэх арга хэмжээг олон улсад хүлээн зөвшөөрсний илэрхийлэл юм.

Мөн шүлхий өвчний дэгдэлтийн үед мөрдөх стандарт ажлын 8 зааврыг боловсруулж, салбарын мэргэжилтнүүдээр хянуулсан бөгөөд эдгээр стандарт ажлын зааврыг хээрийн үзүүлэх сургуулилтаар туршиж, гарсан үр дүнд нь тулгуурлан эцэслэн сайжруулах, албан баримт болгон баталгаажуулах ажлыг МЭҮГ хариуцан ажиллаж байна.

Малын бруцеллёзтой тэмцэх стратеги, төлөвлөгөө нь ХХАА-н сайдын 2015 оны А-154 дугаар тушаалаар багтлагдсан байна. Энэхүү стратегийг 2021 он хүртэл хэрэгжүүлнэ. Батлагдсан стратегийн дагуу жил бүр шинэ төлийг (эм тугал, хурга, ишиг) вакцинд хамруулахаар төлөвлөсөн нь манай орны онцлогт тохирсон, хамгийн зардал багатай арга юм.

Малын бруцеллёзтой тэмцэх стратеги, төлөвлөгөө-г үр дүнтэй хэрэгжүүлэх, орон нутгийн мэргэжилтнүүдийг нэгдсэн арга зүйгээр хангах шаардлага бий болсон тул Малын бруцеллёзтой тэмцэх стандарт ажиллагааны 8 төрлийн зааврыг боловсруулж МЭҮГ-аар батлуулан мөрдөж байна. Ингэснээр дээрх стратегийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаанууд тодорхой, ойлгомжтой болсон гэж үзэж байна.

2.2. Өвчинтэй тэмцэх стратегит үндэслэн ДАЭМБ-ын 2007 оны зөвлөмж, “Нэг эрүүл мэнд” үзэл баримтлалд нийцсэн бруцеллёз, шүлхий өвчний тандалт судалгаа, мониторингийн аргуудыг боловсруулж батлуулан хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

Шүлхий өвчний тандалт, хяналтын тогтолцоонд дэмжлэг үзүүлэх ажилд Швейцарийн САФОСО зөвлөх компани чухал үүрэг гүйцэтгэсэн байна. 2015 оны 2-3 дугаар сард Ховд аймагт гарсан шүлхийн дэгдэлтийн дараах тандалтын загварчлалд дэмжлэг авах хүсэлт ирүүлсний дагуу хамгийн оновчтой загварчлалыг тогтоож өгсний шаардлагатай дээжний тоог тодорхойлсон байна. Мөн энэ хүрээнд САФОСО-гоос УМЭАЦТЛ, Нийслэлийн мал эмнэлгийн лабораторийн ажилтнуудад зориулж тандалтын тогтолцоо, мэдээлэл/өгөгдөл цуглуулах, түүнд дүн шинжилгээ хийх аргын талаар 2 өдрийн сургалт зохион байгуулжээ.

УМЭАЦТЛ-ийн АВИ 3130 генийн дараалал тогтоох машиний тохиргоо нь алдагдсан тул Халдварт өвчин судлалын үндэсний төвийн машиныг ашиглан шүлхийн оношлогоо хийж байв. Төслийн дэмжлэгээр үйлдвэрлэгчээс эксперт урьж ажиллуулан мал эмнэлгийн салбарт цор ганц байдаг дээрх машины засварлуулж, тохиргоо хийлгэсэн байна.

Малын эрүүл мэнд төсөл нь бруцеллёзын вакцинжуулалтын дараах дархлааны түвшинг тогтоох ийлдэс судлалын тандалтыг сайжруулахад анхаарч ба энэ хүрээнд тандалтын протокол болон асуумжийг хялбарчилж цаашид бруцеллёзын стратегийг хянах үйл ажиллагаа болгох зорилт тавин ажилласан байна. Цаашид эрх бүхий байгууллагууд уг ажлыг хийхдээ санамсаргүй түүвэрлэлтийн аргаар 6 аймаг, сонгосон аймаг тус бүрээс 2 сумыг сонгон дээж цуглуулж байхыг зөвлөмж болгожээ.

МЭҮГ-аас шийдвэрлэсний дагуу Малын бруцеллёзын үндэсний лавлагаа лабораторийг УМЭАЦТЛ-ийн Халдварт, паразиттах өвчний оношилгоо тандалтын тасгийг түшиглэн байгуулахад төслөөс 200.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Энэ ажлын хүрээнд лавлагаа ийлдсийн санг баяжуулах, оношилгооны чадавхыг бэхжүүлэх, эмч мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх ажлуудыг шат дараатай хэрэгжүүлсэн байгаа. Лавлагаа лаборатори байгуулагдсанаар бруцеллёзын ийлдэс судлалын шинжилгээний босго таньцыг өөрийн орны нөхцөлд тохируулан баталгаажуулах, аймгуудын мал эмнэлгийн лабораториудад ур чадварын сорил хийх нөхцөл бүрджээ.

Мал эмнэлгийн II шатлалын лабораторийг хөгжүүлэх дунд, урт хугацааны стратеги болон аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лабораториудын үйл ажиллагааны журам, стандартыг төслийн санхүүжилтээр боловсруулсан байна. Энэ хүрээнд ҮБ-ын ХХААБ-аас боловсруулсан Лабораторийн үнэлгээний аргачлалыг ашиглан **аймаг**, нийслэлийн мал эмнэлгийн лабораториудын чадавхыг тогтоон хөгжлийн давуу болон сул талыг илрүүлж, улмаар цаашдын чиг хандлагыг тодорхойлсон байна. Үнэлгээний дүнд үндэслэн мал эмнэлгийн II шатлалын лабораторийг хөгжүүлэх дунд (2020 он хүртэл) болон урт (2030 он хүртэл) хугацааны стратеги болон мал, амьтны өвчнийг оношлох, тандах, эрүүлийг батлах, мал амьтан, тэдгээрийн **гаралтай түүхий** эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүйг баталгаажуулах шинжилгээ хийх, лаборатори хоорондын харилцааг зохицуулах үйл ажиллагааны стандарт журмын төслийг боловсруулж ХХААХҮЯ болон Стандартчилал **хэмжил** зүйн газарт өргөн барихад бэлэн болгожээ.

УМЭАЦТЛ нь мал эмнэлгийн лабораторийн цахим бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинээр бүрдүүлж, програм хангамжийг нэвтрүүлэх, нэгдсэн сан байгуулах ажлыг төсөлтэй хамтран амжилттай хэрэгжүүлж, **21** аймаг, нийслэлийн **мал эмнэлгийн** лабораториудыг нэгдсэн сүлжээнд холбожээ. Үүний үр дүнд дараах давуу талууд бий болсон байна:

- Мал эмнэлгийн лабораториудын нэгдсэн удирдлага, тогтолцоо бүрдэх, шийдвэр гаргагчдыг шаардлагатай мэдээллээр богино **хугацаанд** хангах;
- Мэдээллийн хурд, аюулгүй байдал сайжрах, **мал**, амьтны өвчнөөс-сэргийлэх, тэмцэх арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх;
- Мал эмнэлгийн лабораториудын үйл ажиллагаа, цар хүрээ өргөжих, эдийн засгийн үр өгөөж, бүтээмж нэмэгдэх, орон зай, цаг хугацаанаас үл хамааран мэдээлэл солилцох;
- Улсын хэмжээнд шинжилгээний хариуны хуудсыг нэгдсэн загварт оруулах;
- Мал эмнэлгийн лабораторийн мэргэжилтний одоогийн байдал, эрэлт, нийлүүлэлтийн мэдээллийн нэгдсэн сан бий болох;
- УМЭАЦТЛ-т ашиглагдаж буй эм урвалжийн зарцуулалтад тавих хяналтыг цахим хэлбэрээр шийдэх;
- Лабораторийн шинжилгээний хариуг 1-3 минутанд хүснэгтлэн гаргах;
- Аливаа өвчний гаралтыг газар зүйн байршил, өвчний нэр, малын төрөл зэргээр ангилж газрын зургаар харуулах.

Малын эрүүл мэнд төсөл сүүлийн 3 жилд хийгдсэн бруцеллёзын вакцинжуулалтын дараах тандалтын эцсийн материалыг (судалгааны протокол, илтгэл, цуглуулсан) МЭҮГ-т албан ёсоор хүлээлгэн өгсөн. МЭҮГ эдгээр материалыг сургалт, судалгаа, төлөвлөлтийн зориулалтаар ашиглах боломжтой юм. Өвчний тандалтын өмнөх үр дүн, төслийн дэмжлэгээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, зохион байгуулсан сургалт, мэргэжилтний ур чадварын ахиц зэргээс үзэхэд Монгол улсад шүлхий, бруцеллёзтой тэмцэх арга хэмжээ төсөл эхэлж байсан үеийнхээс илүү системтэй болсон байгаа нь харагдаж байна.

Төслийн шүлхий өвчинтэй тэмцэх бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд олон улсын эксперт урьж Ховд аймагт гарсан шүлхийн дэгдэлтийн дараах тандалт, баруун, зүүн бүсийн шүлхийн тандалтын загварчлалд зөвлөгөө авах, ДАЭМБ-ын Ази-Номхон Далайн бүсийн 29 дүгээр зөвлөгөөн, БНХАУ-Монгол улс-ОХУ-ын Мал эмнэлгийн албадын гурван талт 5 дугаар уулзалтыг Монгол Улсад зохион байгуулах, Пирбрайтын шүлхийн дэлхийн лавлагаа лабораторийн мэргэжилтнүүдийг урьж УМЭАЦТЛ-ийн оношлогооны чадавхийг бэхжүүлэх сургалт зохион байгуулах, оношлогооны багаж хэрэгслийг сайжруулах зэрэг гол ажилд төслийн шууд оролцоогоор дэмжлэг үзүүлсэн байна.

МЭМТ-ийн бруцеллёзын чиглэлээр хийсэн хамгийн чухал хувь нэмэр бол мал эмнэлгийн практикт бруцеллёзын вакцинжуулалтын дархлааны түвшинг тогтоох ийлдэс судлалын тандалтыг нэвтрүүлсэн явдал юм. Энэхүү үр дүнгийн тогтвортой байдлыг хангахын тулд хууль тогтоомж болон практик үйл ажиллагааг уялдуулах, нотолгоонд суурилсан төлөвлөлтийг бүрэн хэмжээнд хэрэгжүүлэх чиглэлээр эрчимжүүлсэн сургалтуудыг зохион байгуулсан байна. Мөн 2015 оны 3 сард Испани улсын бруцеллёзын эксперт Пилар М.Муностай хамтран УМЭАЦТЛ, МЭХ, ЗӨСҮТ-ийн нийт 12 мэргэжилтэнд ийлдэс судлалын шинжилгээг баталгаажуулах талаарх сургалтыг амжилттай зохион байгуулсан. Ийлдэс судлалын шинжилгээг сонгох, түүний хариуг илтгэх гэх мэт маш чухал сэдвүүд уг сургалтанд багтсан байна.

2.3. Монголын мал эмнэлгийн болон эрүүл мэндийн салбарын бүх шатны байгууллага, мэргэжилтэн нь бруцеллёз, шүлхий өвчнийг бүх шатандаа үр дүнтэй хянахад шаардлагатай мэдлэг болон чадвартай болсон байх зорилтын хүрээнд:

Бруцеллёз, шүлхий өвчинтэй тэмцэх арга хэмжээ, лабораторийн оношлогооны сургалтын үр дүнд төвийн болоод аймаг, сумын түвшний байгууллага, мэргэжилтний чадавхийг сайжруулах зорилгоор хэрэгжүүлсэн гол үйл ажиллагаа:

- Байгууллагын дотор баг бүрдүүлэх болон манлайллын сургалтыг Мал эмнэлэг, үржлийн албаны ажилтнууд, аймгуудын мал эмнэлгийн газрын дарга нар, бүсийн мал эмнэлгийн лабораторийн эрхлэгч нарыг хамруулан Хюман Фортис ХХК зохион байгуулсан.
- Talk Talk болон JET Англи хэлний сургуулиуд дээр хэлний сургалтад Мал эмнэлэг үржлийн газар, Биокомбинат ТӨААТҮГ, Мал эмнэлгийн эм, биобэлдмэлийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори, Мал эмнэлгийн холбоо, Стандарт, хэмжил зүйн газар, Стандарт дэвшил ТББ-ын 42 ажилтанг хамруулсан.
- БНХАУ-д Монгол, Орос, Хятадын гурван талт 4 дэх удаагийн уулзалтад 17 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон. Монголын төлөөлөгчид шүлхий өвчинтэй тэмцэх, хил дамнасан өвчинтэй тэмцэх талаар хэрэгжүүлж буй арга хэмжээний сүүлийн үеийн мэдээллийг танилцуулсан. Энэ үед гурван улс шүлхийн тандалтын талаар хамтарсан төсөл боловсруулах, шуурхай мэдээлэл солилцож байхаар тохиролцсон байна.
- Шүлхийн талаарх мэдээлэл бүхий гарын авлагыг бэлтгэн, зүүн аймгийн малчдад түгээсэн, хүүхдэд зориулсан "Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлье" номыг 1 аймагт тараасан.
- Аймгийн хүн, мал эмнэлгийн 17 мэргэжилтнийг мал сүрэгт тогтсон дархлааны түвшинг тогтоох бруцеллёзын ийлдсийн тандалт судалгаа хийж төлөвлөх ур чадвар эзэмших эпидемиологийн сургалтад хамруулсан, мөн аймаг, сумын хүн эмнэлэг болон мал эмнэлэг, төвийн байгууллагуудын ажилтнууд бруцеллёзын оношлогоо, эмчилгээ сэдэвт сургалтад хамрагдсан, 5 аймгийн хүн эмнэлгийн 15 эмч хүний бруцеллёзын дээжийг цуглуулах, тээвэрлэх тухай сургалтад хамрагдсан байна.
- Малын эрүүл мэнд төслөө УМЭАЦТЛ-ийн оношилгоонд зориулсан орчин үеийн эд задлагч, оношлуур, урвалж, хэрэглэгдэхүүн нийлүүлсний үр дүнд шүлхий өвчнийг өмнө нь 72 цагт оношилдог байсан бол одоо 6 цагт багтаан оношлох бүрэн боломжтой болжээ.
- Нийслэлийн мал эмнэлгийн газарт 16.0 сая төгрөгөөр нян өсгөвөрлөх CO2 инкубатор, УМЭАЦТЛ-ийн задлангийн өрөөнд 11.5 төгрөгөөр, Гоц халдварт өвчний оношилгоо тандалтын тасагт 50.0 сая төгрөгөөр нэн шаардлагатай багаж хэрэгсэл, Мал эмнэлгийн хүрээлдэнд 14.0 сая төгрөгөөр бруцеллёзын өсгөвөр, ийлдэс хадгалах гүн хөлдөөгч

худалдан авч өгч хөрөнгө оруулалт хийсэн байна. Үүний зэрэгцээгээр Мал амьтны халдварт, гоц халдварт өвчнийг эрт илрүүлэх, гаралт, тархалтыг **бууруулах**; шуурхай хариу арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, мал эмнэлгийн салбарын төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтыг сайжруулах зорилго бүхий Шуурхай хариу арга хэмжээний төвийг МЭҮГ-т байгуулж 40.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ.

- Төслөөс УМЭАЦГЛ-той хамтран Полимеразын гинжин урвал (ПГУ)-ын арга зүй эзэмшүүлэх ажлын байрны сургалтыг аймгийн лабораторийн эмч нарт зохион байгуулсны үр дүнд орон нутгийн оношилгооны чадавх дээшилж зарим төрлийн нян, вирусээр үүсгэгддэг өвчнийг молекулын түвшинд шуурхай оношлох чадавхтай болжээ. Тухайлбал, хүн-малын эрүүл мэндэд ноцтой хохирол учруулдаг боом өвчнийг аймгийн Мал эмнэлэг ариун цэврийн лабораторит нян судлал, биохимийн шинжилгээгээр оношилдог байсан бол одоо ПГУ ашигладаг болсон байна.
- Дээрхээс гадна бруцеллёзын ийлдсийн тандалт судалгааны мэдээлэлд боловсруулалт хийх сургалт зохион байгуулагдсан, докторант Ц.Чимидцэрэнгийн “Тэмээний бруцеллёз” сэдэвт докторын зэрэг горилох эрдэм шинжилгээний ажилд төсөл дэмжлэг үзүүлсэн байна.

Мэдээлэл, харилцааны ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр:

- Мэдээлэл харилцааны сургалтыг хүн, мал эмнэлгийн байгууллагын 17 ажилтан, ШХА-ийн төслийн ажилтнуудад зориулан зохион байгуулсан. Сургалтад оролцогчид байгууллагын мэдээлэл харилцааны стратегийг хэрхэн боловсруулах, үйл ажиллагааг төлөвлөх, төсвийг хуваарилах талаар ойлголт авсан. Эрүүл мэндийн болон мал эмнэлгийн мэргэжилтнүүд нь өвчин дэгдсэн тохиолдолд өвчний шинж тэмдэг, урьдчилан сэргийлэх талаар энгийн мессежийг хэрхэн боловсруулах, мэргэжилтнүүд иргэдийн асуултад хариулах шуурхай утсыг хэрхэн бий болгох талаар суралцсан.
- Шүлхий өвчний талаарх мэдээлэл бүхий товхимлыг дотоодын болон олон улсын мэргэжилтнүүд боловсруулан, 5000 хувь хэвлэн гаргасан. Товхимлыг Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудад 2014 оны 2-4 дүгээр сард шүлхий өвчин дэгдэх үед малчдад тараасан.
- Телевизийн хоёр сурталчилгаагаар дамжуулан хүнд халдварласан бруцеллёзын үндсэн клиник шинж тэмдэг, дамжих болон урьдчилан сэргийлэх арга замуудын талаар, хаана оношлуулан эмчлүүлэх тухай мэдээллийг түгээсэн. Телевизийн сурталчилгааг гурван сарын хугацаагаар Боловсрол телевизээр нэвтрүүлсэн. Малын эрүүл мэнд төсөл нь Монгол үндэсний олон нийтийн радио, телевизээр 2014 оны 10, 11 үгээр саруудад цацсан хүнд халдварласан бруцеллёзын тухай мэдлэг олгох телевизийн хөтөлбөрийг санхүүжүүлсэн.
- “Олон нийтэд мэдээлэл түгээвэл бруцеллёзоос сэргийлж болно” хэмээх нийтлэлийг 2014 оны 9 дүгээр сард “Өдрийн сонинд” нийтлүүлсэн, “Сүргийн эрүүл мэнд”-ийн талаарх сургалтын гарын авлагыг ХААҮШУОНТ-өөс мэргэжилтнүүдийн тусламжтайгаар боловсруулсан бөгөөд уг сэдвийг Ногоон алт төслийн Увс, Ховд болон Баян-Өлгий аймгийн нэвтрүүлэх төвийн 53 ажилтанд зааж эзэмшүүлсэн.

Малын эрүүл мэнд төслөөс 2012-2016 онд зохион байгуулсан сургалт

Сургалтын сэдэв	Нийт хүн/өдөр	Хүн/өдөр, эмэгтэй	Хүн/өдөр, эрэгтэй
Тархвар зүй/ өвчний хяналт (дархлаажуулалтын дараах тандалт, эмийн зохистой хэрэглээ, мэдээлэлд боловсруулалт хийх)	4206	2136	2070
Лаборатори (Шүлхий, бруцеллёзын оношилгоо)	1446	1023	421
Ерөнхий ур чадвар (Англи хэл, хүний нөөц, хэвлэл мэдээлэлтэй харилцах)	3213	1478	1737
Нийт	8867	4639	4228

Төслийн бүрэлдэхүүн хэсэг-3. Мал эмнэлгийн албан сургалт

3.1. Мал эмнэлэг, биотехнологийн сургуульд хөндлөнгийн үнэлгээ цогц байдлаар хийгдэж үр дүнг бүх ашиг хүртэгч нарт мэдээлэх зорилтын хүрээнд:

Малын эмч бэлтгэх сургалтын хөтөлбөрийг ажлын байранд тавигдаж байгаа хэрэгцээнд нийцүүлэн шинэчилж, эзэмшсэн байвал зохих мэдлэг, ур чадварыг төгсөгчдөд бүрэн эзэмшүүлэх чадавх бүрдүүлэх нь энэ бүрэлдэхүүн хэсгийн нэгэн гол ажил юм. Лондонгийн их сургуулийн Хатан хааны мал эмнэлгийн сургуулийн хөтөлбөрийг жишиг болгон боловсруулсан Мал

эмнэлгийн сургууль (МЭС)-ийн шинэ хөтөлбөр нь Хөдөө аж ахуйн их сургууль (ХААИС)-ийн Хөтөлбөрийн Хороогоор батлагдаж 2015/2016 оны хичээлийн жилээс мөрдөгдөж эхэлжээ. Хөтөлбөрийг боловсруулах явцад Хатан хааны мал эмнэлгийн сургуулийн зөвлөх баг 3 удаа ирж МЭС-ийн Хөтөлбөрийн хорооны гишүүдэд зөвлөгөө өгч, заах агуулга, арга зүйг бодит хичээлээр үзүүлсэн байна.

МЭС-ийн өргөтгөлийн барилгын архитектурын зураг төслийг 160.0 сая төгрөгөөр төслөөс санхүүжүүлэн гүйцэтгүүлсэн байна. Мөн МЭС-ийн мал үзлэгийн хашаа, байрыг төслийн санхүүгийн дэмжлэгээр шинэчлэн барьжээ. Клиник сургалтын байгууламжийн барилгын архитектурын зураг төслийг МЭС хариуцан гүйцэтгүүлсэн бөгөөд Малын эрүүл мэнд төсөл, ХААИС-ийн төлөөлөл болон барилгын салбарын мэргэжилтнээс бүрдсэн 6 гишүүнтэй баг “Хайрхан бар” ХХК-ийг сонгон шалгаруулж 100.0 сая төгрөгөөр төслөөс санхүүжүүлэн барилга угсралтын ажил гүйцэтгүүлсэн байна. Энэхүү шинэ хашаа, байр нь клиник ур чадвар хөгжүүлэх сургалтанд чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд ялангуяа тэнд байрлуулсан мал бэхлэх зогсоолууд нь бүтэц, үйл судлал, клиник оношилгооны хичээл явуулахад ихээхэн ач холбогдолтой болжээ.

Хөтөлбөрийн агуулга, арга зүй, үнэлгээний системийг нэвтрүүлэх боломж бүрдүүлсэн клиник, лаборатори, багаж хэрэгсэл бүхий сургалтын орчинг шинээр бий болгоод зогсохгүй орчин үеийн шаардлагад нийцсэн номын сан, лекцийн танхимийг 120.0 сая төгрөгөөр байгуулсан байна.

3.2. Боловсон хүчний хэрэгцээнд суурилсан хүйсийн тэгш байдлыг хангасан Хүний нөөцийг чадавхжуулах мастер төлөвлөгөө боловсруулж Мал эмнэлэг, биотехнологийн сургууль дээр хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

МЭС-ийн хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд мэргэжил дээшлүүлсэн дотоодын мэргэжилтэн, багш нарын зардлыг төслөөс санхүүжүүлсэн байна. Мөн МЭС-ийн багш нарт зориулан баг бүрдүүлэх болон манлайллын сургалтыг зохион байгуулсан ба сургалтын хүрээнд хувь хүний болон сэтгэл зүйн зарим асуудлыг судлан, эдгээрийг баг бүрдүүлэхэд хэрхэн эерэгээр ашиглах аргачлалыг эзэмшүүлсэн байна. Түүнээс гадна тус сургуулийн 4 багш Talk Talk Англи хэлний сургууль дээр хэлний сургалтад хамрагдаж Англи хэлний ур чадвараа (1-10 гэсэн хэмжүүртэй) 3 шатаар дээшлүүлсэн, Шинэ Зеландын Массигийн их сургуулийн профессор Рожер Моррис төслийн санал бичих семинарыг МЭС-ийн багш нарт зориулан зохион байгуулсан, багш н.Цогбадрах Ирландын Килдар хот дахь догол болон спортын анагаах ухаанаар төрөлжсөн EquiVET сургууль дээр дагалдан сургалтад хамрагдсан байна.

Мөн хоёр сар хүртэлх хугацаагаар олон улсын интершип хөтөлбөрт хамрагдаж мэргэжил дээшлүүлэх боломж олгон сонгон шалгаруулалт зарласны дагуу МЭС-ийн багш Б.Отгонтөгс Английн Хатан хааны мал эмнэлгийн сургуульд сургалтын хөтөлбөр, МЭС-ийн багш Б.Баяртогтох Ирландын Адууны эмнэлэгт адууны оношилгоо, эмчилгээ, УМЭАЦТЛ-ийн ажилтан А.Улаанхүү Гонконгийн их сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургуульд шувууны томуугийн оношилгооны аргачлал чиглэлээр тус тус суралцжээ.

3.3. Сургалтын материал боловсруулах, сургалтын лабораторийн үндсэн тоног төхөөрөмжийг худалдан авах, номын сангийн хэрэгцээнд суурилсан мастер төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

МЭС-ийн цахим хуудас - интранетийг хийж, багш нар өөрийн хичээл, танилцуулгуудыг оюутнуудтайгаа хуваалцах боломжийг олголоо. Ингэснээр хичээлийг дуудаж өгч бичүүлэх хэлбэрийг багасган лекцийн үеэр хэлэлцүүлэг өрнүүлэх боломжийг хангаж өгсөн байна. Мөн нээлттэй эх платформ болох сургалтын (Moodle) системийг Инфокон ХХК боловсруулан нийлүүлж, хэрэглээний талаар багш, оюутнуудад зориулан танилцуулга, сургалт зохион байгуулсан.

Сургалтын хөтөлбөр боловсруулах багийн гишүүд хийж нүйцэтгэж байгаа ажлаа богино хугацаанд дуусгах, сайжруулах, шаардлагагүй бичиг цааснаас зайлсхийх, менежментийн багтай харилцаа холбоогоо хурдасгахад нь зориулан нийт 11 зөврийн компютерийг олгосон байна. Мөн сургууль дээр Клиник ур чадварыг хөгжүүлэх төвийг байгуулж 110.0 сая төгрөгийн үнэ бүхий нэн шаардлагатай тоног төхөөрөмж, 11.5 сая төгрөгийн үнэ бүхий задлан шинжилгээний хичээлийн хэрэгсэл, 11.0 сая төгрөгийн үнэ бүхий 80 ширхэг санал хураах төхөөрөмж, мал эмнэлгийн холбогдолтой мэдээллийн эх үүсвэрийг орчуулан сургалтад ашиглах, судалгааны үр дүнгээ олон улсын сэтгүүлд нийтлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор нийт 40 ширхэг Англи-Монгол, Монгол-Англи толь бичгийг тус тус худалдан авч өгсөн.

ТАВ. ҮНЭЛГЭЭ

Төслийн үйл ажиллагаанд үнэлгээ хийхдээ төсөл хэрэгжсэнээс хойших үр дүнгийн үнэлгээг өссөн дүнгээр тооцсоноос гадна үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэхдээ тухайн жилийн төлөвлөгөөний биелэлтээр тооцож хувиар илэрхийлэн гаргалаа.

5.1. Төслийн хүрээнд 2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

№	Үйл ажиллагаа	Үнэлгээ
Үр дүн 1. Монгол улсын мал эмнэлгийн алба олон улсын жишгийн дагуу зохион байгуулагдана.		
Үр дүн 1.1. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн төслийн УИХ-д өргөн барихад дэмжлэг үзүүлэх.		
1.1.1.	Хуулийн төсөл, зөвлөмж, удирдамжийг хянан үзэх	100%
1.1.2.	Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх	100%
1.1.3.	Хуулийн төслийн талаар мэдээлэл түгээх	100%
1.1.4.	УИХ-ын БОХХААБХ-ны гишүүдийн танилцах аялалд явуулах	70.0%
1.1.5.	Төрөөс ХХАА-н талаар баримтлах бодлого болон салбарын ерөнхий танилцуулгыг англи, монгол хэлээр хэвлэх зардал	100%
Үр дүн 1.2. Хуулийг хэрэгжүүлэх техникийн ур чадварыг бэхжүүлэх.		
1.2.1.	Хуулийг хэрэгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулах ажилд дэмжлэг үзүүлэх	0
1.2.2.	Төрийн үйлчилгээ үзүүлж байгаа малын эмч нарыг сургах	0
1.2.3.	Хууль хэрэгжүүлэх талаар үндэсний сургалт зохион байгуулах	0
1.2.4.	Аймаг, сумдад ажилладаг төрийн малын эмч нарт зориулсан сургалт семинар	100%
1.2.5.	Хувийн малын эмч нарт зориулсан сургалт	100%
1.2.6.	Менежмент, хүний нөөц, жендерийн сургалт	100%
1.2.7.	Олон нийттэй хэрхэн харилцах тухай сургалт	100%
1.2.8.	Шинэ хуулийг дэмжих болон хэрэгжүүлэх талаар шийдвэр гаргагч нарт зориулан аялал зохион байгуулах	50.0%
1.2.9.	Малчдад шинэ хуулийн төслийн талаар мэдээлэл түгээх	70.0%
1.2.10.	Талбарын эпидемиологийн сургалтанд малын эмч нарыг хамруулах	100%
1.2.11.	Шинэ хууль батлагдан гарахтай холбогдуулан мал эмнэлгийн техникийн баримт бичиг болох журам, заавар, стандарт боловсруулахад дэмжлэг үзүүлэх	0
1.2.12.	МЭҮГ-г шуурхай удирдлагын нэгж байгуулахад дэмжлэг үзүүлэх	100%
1.2.13.	Эмийн үлдэгдлийн үндэсний хөтөлбөртэй холбоотой дэмжлэг үзүүлэх зардал	100%
1.2.14.	Хүний нөөц, байгууллагын удирдлага, манлайллын талаарх сургалт	100%
1.2.15.	Малын эмч нарын англи хэлний сургалт	100%
1.2.16.	ХХААЯ-аас зохион байгуулах "Тэргүүний малчдын зөвлөгөөн"-ийг дэмжих	100%
Үр дүн 2. Монгол улс бруцеллэз, шүлхий өвчинтэй тэмцэх ур чадвар, хэрэгсэлтэй болно.		
Үр дүн 2.1. Шинжлэх ухаанд суурилсан шүлхий өвчинтэй тэмцэх стратеги, "Нэг эрүүл мэнд" үзэл баримтлалд тулгуурласан бруцеллэзтэй тэмцэх стратеги боловсруулна.		
2.1.1.	Шүлхийн үндэсний хэмжээний уулзалт зохион байгуулах	70.0%
2.1.2.	Шүлхийтэй тэмцэх стратегийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх	100%
2.1.3.	Шүлхийтэй тэмцэх стратегит үндэслэн стандарт үйл ажиллагааны заавар боловсруулах	70.0%
2.1.4.	Сэрэмж дээшлүүлэх үйл ажиллагааг дэмжих	100
2.1.5.	Бруцеллэзтэй тэмцэх үед мөрдөх стандарт ажиллагааны заавар боловсруулах	100%
2.1.6.	"Нэг эрүүл мэнд" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	80.0%
Үр дүн 2.2. Бруцеллэз, шүлхий өвчний тандалт, мониторингийн тогтолцоо сайжирна.		
2.2.1.	Тандалт, вакцинжуулалтын төлөвлөлт, дүн шинжилгээнд дэмжлэг үзүүлэх	100%
2.2.2.	Шүлхийн вакцинжуулалтын тандалтыг аймгийн мал эмнэлгийн лабораториуд шингэн фазат саатуулаг ЭЛИЗА-аар хийх ажлыг зохион байгуулах	90.0%

2.2.3.	УМЭАЦТЛ шүлхийн олон улсын ур чадварын сорилд хамрагдахад дэмжлэг үзүүлэх	100%
2.2.4.	Лабораторийн мэдээллийн менежментийн систем бий болгох	100%
2.2.5.	Худалдан авалт	100%
2.2.6.	Баруун бүсийн шүлхийн тандалт	100%
2.2.7.	Ийлдсийн тандалт хийхэд дэмжлэг үзүүлэх	100%
2.2.8.	Бруцеллёзын лавлагаа лабораторийн үйл ажиллагааг дэмжих, сургалт хийх	100%
2.2.9.	Аймгийн лабораторийн бруцеллёзын оношилгооны чадавхийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	90.0%
2.2.10.	Өвчнөөс сэргийлэх сэрэмж дээшлүүлэх	70.0%
2.2.11.	Аймгуудаас ирүүлсэн тандалтын төслүүдэд дэмжлэг үзүүлэх	90.0%
2.2.12.	УБ хот орчмын сүүний үнээний бруцеллёзын тандалт	90.0%
Үр дүн 2.3. Бруцеллёз, шүлхий өвчинтэй тэмцэх ур чадвар бүх түвшинд бэхжинэ.		
2.3.1.	Аймгуудын шүлхий өвчинтэй тэмцэх чадавхийг сайжруулах	70.0%
2.3.2.	Олон улсын уулзалтад оролцох, дэмжлэг үзүүлэх	100%
2.3.3.	Шүлхий болон гоц халдварт өвчний тархалтыг хязгаарлах зорилгоор байгуулсан хяналтын 4 цэгт дэмжлэг үзүүлэх	100%
2.3.4.	Хяналтын цэгийн мэргэжилтнүүдийн чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	100%
2.3.5.	Бүсийн лабораториудын эмч, мэргэжилтнүүдэд зориулан УМЭАЦТЛ-иос явуулах сургалтад дэмжлэг үзүүлэх	100%
2.3.6.	Монгол Улсын шүлхийн хяналтын хөтөлбөрийг хэлэлцэх ДАЭМБ-ын 84-р чуулганд оролцох зардал	100%
2.3.7.	Зүүн өмнөх Ази, Хятадын шүлхий өвчний хяналтын хөтөлбөрийн уулзалт	100%
2.3.8.	ОУ-ын эксперт урьж эпидемиологийн сургалт зохион байгуулах	100%
Үр дүн 3. Хэрэгцээнд суурилсан мал эмнэлгийн боловсролыг үр дүнтэй болгох.		
Үр дүн 3.1. ХААИС-ийн МЭС-ийн төгсөгчдийн эзэмшсэн байвал зохих мэдлэг, ур чадварт үндэслэн сургалтын хөтөлбөрөө сайжруулна.		
3.1.1.	Малын эмч болон туслах ажилтны хэрэгцээг тодорхойлох судалгаа хийх	100%
3.1.2.	Хөтөлбөр боловсруулах болон хэрэгжүүлэхэд гаднаас дэмжлэг үзүүлэх	100%
Үр дүн 3.2. Хүний нөөцийг бэхжүүлнэ.		
3.2.1.	МЭС-ийн хүний нөөцийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	80.0%
Үр дүнт 3.3. Сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй зохион байгуулахад шаардагдах сургалтын материал, сургалтын лаборатори, номын сан, лекцийн танхим, бусад хэрэгцээтэй тоног төхөөрөмжийг худалдан авахад дэмжлэг үзүүлнэ.		
3.3.1.	Номын сан болон лекцийн танхимд зориулж худалдан авалт хийх	100%
Үр дүн 4. Төсөл хэрэгжүүлэх нэгж		
Үр дүн 4.1. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохион байгуулалт, санхүүжилт, менежмент		
4.1.1.	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардлууд	80.0%
4.1.2.	ХХААХҮЯ-аас Малын эрүүл мэнд төсөл болон мал эмнэлгийн үйлчилгээнд аудит хийх	100%
4.1.3.	Англи хэл дээрх баримт материалуудыг хянуулах	60.0%
4.2. Гадны зөвлөх үйлчилгээний менежмент		
4.2.1.	Олон улсын зөвлөх үйлчилгээ	80.0%
4.2.2.	Малын эрүүл мэнд төслөөс жендерийн тэгш оролцоог хангах менежментэд дэмжлэг үзүүлэх	80.0%
4.3. Малын эрүүл мэнд төслийн хаалт болон төслийн үр дүнг тайлагнах		
4.4. Шинэ төсөл “МАН-н тогтвортой менежмент ба маркетинг”-ийн төлөвлөлт		
Дундаж үнэлгээ		86.0%

5.2. Төслийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ
(2016 оны жилийн эцэсийн байдлаар)

№	Зорилт, үйл ажиллагаа	Үнэлгээ
Зорилт 1. Мал эмнэлгийн албаны ажил үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлэхээр бодлого, хууль тогтоомжийг шинэчлэх		75.0%
1	1.1. Бие даасан Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг УИХ-д өргөн мэдүүлж, дэмжлэг авах	90.0%
2	1.2. Хуулийг хэрэгжүүлэх техникийн ур чадварыг бэхжүүлэх.	60.0%
Зорилт 2. Бруцеллэз болон шүлхий өвчинтэй үр дүнтэй тэмцэх, хэмнэлттэй хяналтын хөтөлбөр бий болгох		96.7%
3	2.1. Шинжлэх ухаанд суурилсан шүлхийтэй тэмцэх стратеги, "Нэг эрүүл мэнд" зарчимд үндэслэсэн Бруцеллэзтой тэмцэх стратеги боловсруулах.	100%
4	2.2: Өвчний тандалтыг сайжруулж бруцеллэз, шүлхий өвчний тандалт, хяналтын систем бий болгох.	100%
5	2.3. Бүх түвшинд шүлхий, бруцеллэзтой тэмцэхэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг сайжруулсан байх.	90.0%
Зорилт 3. Малын эмч бэлтгэх албан ёсны боловсролын агуулга, арга зүйг боловсронгуй болгох		93.3%
6	3.1. Сургалтын хөтөлбөрийг Монгол Улсын хэрэгцээнд нийцүүлж, мал эмнэлгийн сургууль төгсөгчийн эзэмшсэн байвал зохих мэдлэг, ур чадвартай уялдуулан шинэчлэх	100%
7	3.2: Хүний нөөцийг чадавхжуулах	80.0%
8	3.3: Сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай материалын дэмжлэг үзүүлэх	100%
Дундаж үнэлгээ		90.0%

5.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгийн нэгтгэл

Төсөл хэрэгжиж эхэлснээс хойш жил бүр гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Засгийн газарт танилцуулж байв. (Үнэлгээний дүнг доорх хүснэгтээс харна уу)

№	Үзүүлэлтүүд	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
1	Төсөл хэрэгжсэнээс хойших үр дүнгийн үнэлгээ	23.3%	50.0%	75.0%	=	90.0%
2	Тухайн жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээ	84.2%	86.6%	80.0%	84.4%	86.0%

Дээрхээс гадна төслийн эхний 2 жилийн үйл ажиллагааг хянах, үлдэж байгаа хугацаанд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд шаардлагатай өөрчлөлтийг оруулах зорилгоор 2013 онд дунд хугацааны үнэлгээ хийсэн байна. Дунд хугацааны үнэлгээ хийхдээ оролцогч талуудад зориулсан уулзалт, семинар зохион байгуулах, түнш байгууллагуудын төлөөлөлтэй уулзаж төслийн хүрээнд хийгдэж байгаа ажлын талаар зөвлөлдөх, ярилцах аргыг хэрэглэсэн байна. Дунд хугацааны үнэлгээний үр дүнд төслийн логик хүрээг шинэчлэн сайжруулсан бөгөөд чадавх бэхжүүлэх ажлын хувьд төсөлд оролцогч талуудын хоорондох харилцаа холбоо болон олон нийтэд мал, амьтны өвчинтэй холбогдолтой мэдээллийг түгээхэд онцгойлон анхаарч ажиллахыг зөвлөсөн байна.

Мөн төслийн үйл ажиллагаануудын харилцан хамаарал, үр ашиг, үр нөлөө, тогтвортой байдлыг хянан нягтлах, мал аж ахуйн тогтвортой менежмент, маркетингийн талаар цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг тодорхойлох зорилгоор 2015 онд Швейцарийн Холбооны Улсаас шинжээчид ирж хөндлөнгийн үнэлгээ хийж гүйцэтгэсэн байна. Эдгээр үнэлгээгээр өгсөн зөвлөмжийг 2017 оноос хэрэгжиж эхлээд байгаа Малын эрүүл мэнд – ногоон алт төслийн баримт бичигт тусган хэрэгжүүлж байна.

ЗУРГАА. ДҮГНЭЛТ

- Малын эрүүл мэнд төслийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 86.0 % байна. Харин төслийн үр дүнг төсөл хэрэгжсэнээс хойших хугацааны өссөн дүнгээр тооцож үзэхэд 90.0 % буюу “хангалттай сайн” үнэлгээтэй байна.
- Тайлант хугацаанд УИХ-ын сонгуулийн жил таарсантай холбоотойгоор Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаан, УИХ-ын чуулганаар хэлэлцэх үйл явц удааширч төслийн баримт бичгийн 1.2.-т тусгагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах техник ур чадварыг бэхжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилт 60.0 % буюу “хангалтгүй” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.
- Малын эмч бэлтгэх сургалтын хөтөлбөрийг ажлын байранд тавигдаж байгаа хэрэгцээнд нийцүүлж, төгсөгчийн эзэмшсэн байвал зохих мэдлэг, ур чадвартай уялдуулан шинэчлэх үйл ажиллагаа болон Сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай материалын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа “хангалттай сайн” хэрэгжсэн бөгөөд цаашид төслийн үр дүн тогтвортой хадгалагдах боломж бүрдсэн байна.